



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 16 өдөр

Дугаар A/369

Мандалговь

Махны нөөц бүрдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 285 дугаар тогтоол, Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн A/11 дүгээр тушаал, Улсын онцгой комиссын 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн өргөтгөсөн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2019-2020 оны намар, хаврын хэрэгцээт махны нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Хоёр. Сум бүр 1000 толгойгоос доошгүй хонины махыг хавсралт зөвлөмжийн дагуу бэлтгэж махыг Улаанбаатар хот дахь хуваарилагдсан цэгт буюу аймгийн төвд хүргэх ажлыг 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор зохион байгуулж ажиллахыг даалгасугай.

Гурав. Мах бэлтгэн нийлүүлэх ажлын хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т, мэргэжлийн арга зүй, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн)-д нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

488191047

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар  
сарын 15-ны өдрийн 209. дугаар  
захирамжийн хавсралт

### ЗӨВЛӨМЖ

Засгийн газрын 2019 оны 285 тоот тогтоолыг хэрэгжүүлэх, ХХААХҮ-ийн сайд, Малын ерөнхий эмчийн өгсөн үүрэг чиглэлийн дагуу мал эмнэлгийн баталгаатай, гарал үүсэл тодорхой эрүүл малын махыг нийтийн хүнсний хэрэгцээнд нийлүүлэх, нөөц бүрдүүлэх зорилгоор мах бэлтгэх ажлыг сумдын удирдлагууд, мэргэжилнүүдтэй хамтран зохион байгуулж ажиллана. Үүнд:

1. Сум бүр мал мах бэлтгэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж малчид мал бүхий иргэдээс нийлүүлэх хонийг амьдаар болон гулуузаар аймагт хүргүүлэх (18 кг-аас дээш жинтэй байхаар тооцож бэлтгэнэ)
2. Нийлүүлэх мал нь малчны гар дээрээс шууд хэрэглэгчдэд дамжлагагүйгээр нийслэлийн хэрэглэгчдийн хэрэгцээнд нийлүүлэгдэх ба эрүүл ахуй ариун цэврийн шаардлагад нийцсэн, гарал үсэл тодорхой байх
3. Малчид Улаанбаатар хотруу шууд нийлүүлэх тохиолдолд Сумын Мал эмнэлэгийн тасаг, Мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн эмч нарын тодорхойлолт, мал махны эрүүл мэндийн гэрчилгээг олгож Улаанбаатар хотод хуваарилагдсан газарт хүлээлгэж өгөх (зөвхөн бэлтгэгдсэн мах)
4. Мал махыг зах зээлийн одоогийн ханшаар авах ба малыг нядлаж гулуузлах, гэдэс толгой, дайвар бүтээгдэхүүнийг уламжлалт монгол аргаар бэлтгэх (Өлөнг нэхийний дотор хийлгүй тус тусад нь хадгалж хүлээлгэж өгөх)
5. Махны үнийг 2019 оны 11 дүгээр сард багтаан ХАА-н биржээс нийлүүлэгч нарт олгох тул овог нэр, харилцах дансны дугаарыг нь бүртгэж авахад анхаарах
6. Хонио зах зээлд нийлүүлэх, нийлүүлж байгаа малчдын судалгааг гаргаж аймгийн МЭГ-т өдөр бүр ирүүлэх (Ц.Адъяасүрэн 88941353)
7. Бэлтгэн нийлүүлэх, бүртгэл тооцоо хийх, худалдах мөнгө буцаан олгох талаар сумдын Мал эмнэлгийн тасаг чиглүүлж ажиллах
8. Махыг гулуузаар хүлээн авах бол ажлын хэсгийн шийдвэрээр мах, түүхий эд хадгалах байр, зооринд горимын дагуу хадгалах